



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 08 дугаар сарын 25 өдөр

Дугаар 45

Хэрлэн сум

ХХХХV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 45 дугаар хурал цомхотгосон хэлбэрээр 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 76,6 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. БОЭТ-ийн Халдварт мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг, хүүхдийн сэхээн амьдруулах тасагт ханын хүчилтөрөгчийн систем байгуулах зардлыг санхүүжүүлэх тухай хэлэлцэх,

Бүсийн оношилгоо эмчилгээний төв

2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан ариутгал, халдваргүйтгэл хийх бодисын шаардагдах тооцоо, зардлыг танилцуулах,

Боловсрол, соёл урлагийн газар

3. "Мөнх амийн найдвар" Баптист сүмийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ажлын дүнг танилцуулах,

Онцгой байдлын газар

4. "ДБЭХС" ТӨХК-ийн хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлж, өргөтгөх төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын "ТВЕА" ХХК-ийн 31 иргэний гэрийн ажиглалтын хугацаа дуусаж байгаатай холбогдуулан шинжилгээний дүн болон ариутгал, халдваргүйтгэлийн талаар танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газар

5. Онцгой комиссын гишүүдийн саналаар нэмж хэлэлцүүлэх асуудлын талаар,

Онцгой комиссын гишүүд

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. "Мөнх амийн найдвар" Баптист сүмд Мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулсан хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил, аймгийн Онцгой комиссын даргаас өгсөн 4 төрлийн үүргийг хэрэгжүүлсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагуудын хяналтын доор үйл ажиллагаа явуулахыг аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

2. БОЭТ-ийн Халдварт мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг, хүүхдийн сэхээн амьдруулах тасагт ханын хүчилтөрөгчийн систем байгуулахад шаардагдах 8.376.980 төгрөгийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэв.

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Н.Энхболд нарт:

1.1. БОЭТ-ийн Халдварт мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг, хүүхдийн сэхээн амьдруулах тасагт ханын хүчилтөрөгчийн систем байгуулах боломжтой эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргахыг,

Хоёр. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын орлогч,

Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга,

Бүсийн оношилоо эмчилгээний төвийн захирал Д.Должин нарт

2.1. БОЭТ-ийн Халдварт мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг, хүүхдийн сэхээн амьдруулах тасагт ханын хүчилтөрөгчийн систем байгуулахад шаардагдах 8.376.980 төгрөгийн санхүүжилтийг Мэргэжлийн хяналтын газрын хэмжил зүйн хяналтын улсын байцаагчийн болон Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дүгнэлт гарсны дараа санхүүжилтийн гүйлгээ хийлгэхийг,

Гурав. Боловсрол, соёл урлагийн газрын дарга,

Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа-д

3.1. Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ариутгал, халдваргүйтгэлийн дэглэмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд хяналт тавих, зөвлөгөө өгөх ажлын хэсгийг томилох захирамжийн төсөл боловсруулж батлуулахыг,

3.2. Аймгийн хэмжээнд 2-3 настай хүүхэдтэй ажил, хөдөлмөр эрхэлдэг эцэг, эхчүүдийн судалгааг гаргаж танилцуулахыг,

3.3. 2-3 настай хүүхэдтэй эцэг эхчүүдийн ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх талаар захирамжийн төсөл боловсруулж, танилцуулахыг,

Дөрөв. Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын

Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга

Онцгой комиссын гишүүн Оюунаа нарт:

4.1. Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн Чойбалсан цуглаан сүмийн үйл ажиллагаанд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт зохион байгуулж, дүнг дараагийн 46 дугаар хуралд танилцуулахыг,

4.2. "Мөнх амийн найдвар" Баптист сүмийн гадна ариун цэврийн байгууламжид Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах, уг ариун цэврийн байгууламжийг бүрэн хаахыг,

4.3. Дотор ариун цэврийн өрөөний эрүүл ахуйн нөхцлийг сайжруулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх, хэвийн ажиллагаанд оруулж хяналт тавихыг,

4.4. Мөнх амийн найдвар Баптист сүмийн үйл ажиллагааг хязгаарлалттайгаар ажиллуулахдаа уг сүмийн гадна, дотно байрлуулсан камерын хяналтыг ашиглах чиглэлээр албан бичигт тусгаж ажиллахыг,

4.5. Цуглаан зохион байгуулах заалуудад суудал болон хүний тоог зааж, цөөн хүн хамруулахаар зохион байгуулахыг,


4.6. Аймгийн Онцгой комиссын даргын Баптист сүмд өгсөн үүрэг, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газраас өгсөн хугацаатай албан шаардлагыг биелүүлсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагын хяналтын дор үйл ажиллагаа явуулахыг,

Тав. Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын
Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга,
Эрүүл мэндийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
"ДБЭХС" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал,
Онцгой комиссын гишүүн Г.Отгонбаатар нарт:

5.1."ДБЭХС" ТӨХК-ийн үйлдвэрийн хашаанд гэрийн ажиглалтад байгаа БНХАУ-ын "ТВЕА" ХХК-ийн 5 инженер, техникийн ажилтныг гэрийн ажиглалтын хугацаа дуусах өдөр буюу 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хот руу тогтоосон зам, маршрутаар, халдвар хамгааллын дэглэмийг сахиж зорчих талаар зөвлөмжийг хүргүүлэхийг,

5.2."ДБЭХС" ТӨХК-ийн үйлдвэрийн хашаанд байгаа БНХАУ-ын "ТВЕА" ХХК-ийн иргэдийн ажил, үйлчилгээг гүйцэтгэх явцад, дотоод хяналтыг тавих, шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нэг талаас аймгийн Онцгой комиссыг төлөөлж Онцгой байдлын газар, нөгөө талаас "ДБЭХС" ТӨХК, БНХАУ-ын "ТВЕА" ХХК хооронд хамтарсан гэрээ байгуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА